



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар №39

Шивээговь сум

Харгалзан дэмжигчээр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гэр бүлийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.2, 65.1.3, 67 дугаар зүйлийн 67.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1, 73 дугаар зүйлийн 73.2.4 дэх заалт, сумын Засаг даргын 2022 оны А/114 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсгийн шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 1 дүгээр багийн иргэн Сартуул овогтой Уранцэцэгийн Анхбаяр /ЕЙ85020116/ нь тал харвалтын улмаас байнгын асаргаанд байдаг гачигдлыг харгалзан үзэж эгч болох Далай ван овогтой Санжийн Минжбадгарыг харгалзан дэмжигчээр тогтоосугай.

2.Харгалзан дэмжигч С.Минжбадгарт хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх), 1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Отгонбаатар) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ажлын хэсгийн ахлагч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

